

## ДАМЖУУЛАН ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ

201... оны ... дугаар сарын ... өдөр  
хот

№

Улаанбаатар

Нэг талаас \_\_\_\_\_  
(иргэн, хуулийн этгээдийн нэр)  
(цаашид “Түрээслэгч” гэнэ.)-ыг \_\_\_\_\_ үндсэн дээр  
(байгууллагын дүрэм, итгэмжлэл)  
\_\_\_\_\_ төлөөлж, нөгөө талаас  
(эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)  
\_\_\_\_\_ (цаашид “Дамжуулан түрээслэгч” гэнэ.)  
(иргэн, хуулийн этгээдийн нэр)  
-ыг \_\_\_\_\_ үндсэн дээр \_\_\_\_\_  
(байгууллагын дүрэм, итгэмжлэл) (эцэг/эх/-ийн нэр, нэр, албан тушаал)  
төлөөлөн дараахь гэрээг байгуулав.

### 1. НИЙТЛЭГ ЗААЛТ

- 1.1. Энэ гэрээний салшгүй хэсэг болох хавсралт №\_\_-ийн дагуу түрээслэгч нь байрыг түр хугацаагаар дамжуулан түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлнэ.
- 1.2. Түрээслэгч түр хугацааны эзэмшил, ашиглалтад байгаа байрыг дамжуулан түрээслэхдээ “Түрээслүүлэгч”, “Түрээслэгч”-ийн хооронд байгуулсан байр түрээслэх тухай 200\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдөр байгуулсан гэрээ №\_\_-ийн нөхцөлийг мөрдлөг болгоно.

### 2. Дамжуулан түрээслэх зорилго

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_.

### 3. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Түрээслэгч нь дамжуулан түрээслэгчид зориулалтын дагуу ашиглаж болох байрыг шилжүүлнэ.
- 3.2. Түрээслэгч нь дамжуулан түрээслэгдэж байгаа байрыг дамжуулан түрээслэгч хэрхэн ашиглаж байгаа байдалд хяналт тавих эрхтэй.
- 3.3. “Дамжуулан түрээслэгч”-ийн үүрэг:
  - 3.3.1. Түрээсийн байрыг зөвхөн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглана.
  - 3.3.2. Түрээсийн байрыг бүрэн бүтэн байлгах, эрүүл ахуйн цэвэр байдлыг болон галын аюулгүй байдлыг хангана.
  - 3.3.3. Түрээсийн байранд өөрийн зардлаар цаг хугацаанд нь урсгал болон бусад засварыг хийнэ.
  - 3.3.4. Сантехникийн, цахилгааны болон бусад тоног төхөөрөмжийн ослын шинж байдал илэрсэн тохиолдолд түрээслэгчид нэн даруй мэдэгдэнэ.
  - 3.3.5. Түрээслэгчийн зөвшөөрөлгүйгээр дамжуулан түрээслэж байгаа байранд урсгал ба их засварын ажил хийхгүй, сантехникийг өөрчлөн тоноглохгүй байна.
  - 3.3.6. ....
- 3.4. Дамжуулан түрээслэгчийн буруутай үйлдлээс болон шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь аваагүйн улмаас дамжуулан түрээслэж байгаа байр ослын байдалтай болсон тохиолдолд дамжуулан түрээслэгч өөрийн хүч, зардлаар сэргээх буюу хохирлыг хууль тогтоомжийн дагуу барагдуулна.

*Үргэлжлэл бий ....*